



Үндэсний виз мэдүүлэх заавар

Мэргэжлийн боловсролтой ажиллах хүчин (§ 18a AufenthG)

Дээд боловсролтой ажиллах хүчин (§ 18b Abs. 1 AufenthG)

Мэдээллийн Технологийн (IT) ажлын туршлагатай мэргэжилтэн

Үндсэн заавар

- Гэрчилгээ, Диплом болон бусад баримт бичгийн эх хувийг өгнө. Таны визийн мэдүүлгийг шийдвэрлэсний дараа эх хувийг буцаан олгоно.
- Таны визийн мэдүүлгийг шийдвэрлэхийн тулд Герман дахь Холбооны Хөдөлмөрийн Товчоо болон Гадаадын Харьяат Иргэдийн газрын зөвшөөрөл авдаг. Тус газраас зөвшөөрөл ирсний дараа виз олгох боломжтой.
- Визийн мэдүүлгийг дунджаар ажлын 10 хоногт шийдвэрлэнэ. Зарим тохиолдолд илүү хугацаа орж болно.
- Визийн мэдүүлгийг өгөхдөө нислэгийн тийзийн захиалга өгөх шаардлагагүй.
- ЭСЯ-наас нэмэлт бичиг баримт шаардаж болно.
- Бүрэн гүйцэд бус визийн мэдүүлэг өгөх нь шийдвэрлэх хугацааг уртасгах бөгөөд цаашлаад татгалзах эрсдэлтэй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэх ажлын 10 хоног дотор утсаар болон И-Мэйлээр лавлан асуух шаардлагагүй. Энэ нь визийн хэлтсийн ачааллыг нэмэгдүүлэх тул виз мэдүүлэгч бүрт тухайлан хариулах боломжгүй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэхэд олон хүчин зүйлс, нөхцөл байдлыг харгалзан шалгах учраас зааврын дагуу бичиг баримтаа бүрэн бүрдүүлж өгөх нь виз гарах баталгаа биш.
- Маягтыг визийн хэлтсээс үнэ төлбөргүй авах боломжтой. Виз мэдүүлэхэд үйлчилгээний хураамж төлөх бөгөөд тухайн хураамжийг виз татгалзсан, мэдүүлгээ буцаан авсан аль ч тохиолдолд эргүүлэн олгохгүй.
- Виз мэдүүлэх бичиг баримт бүрдүүлэхдээ ямар нэгэн байгууллага эсвэл гуравдагч этгээдийн туслалцаа, үйлчилгээг ашиглах шаардлагагүй. Өгсөн мэдүүлгийн хариуцлага, үр дагаврыг зөвхөн виз мэдүүлэгч өөрөө хариуцна.
- Виз мэдүүлэгч нь ЭСЯ-ны Консулын хэлтэст биечлэн ирж бичиг баримтаа өгнө.



Ерөнхий мэдээлэл

Мэргэжлийн боловсролтой ажиллах хүчин (§18a AufentG)

Германд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн боловсролтой хүнд эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу ажиллах эрхтэй оршин суух зөвшөөрөл олгож болно.

Гадаадад эзэмшсэн зарим нэг дээд боловсролыг Германд ердөө мэргэжлийн боловсрол гэж тооцож болно гэдгийг анхаарна уу.

Дээд боловсролтой ажиллах хүчин (§18b Abs.1 AufentG)

Германд хүлээн зөвшөөрөгдсөн дээд боловсролтой хүнд эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу ажиллах эрхтэй оршин суух зөвшөөрөл олгож болно.

Мэдээллийн Технологийн (IT) ажлын туршлагатай мэргэжилтэн

Сүүлийн 7 жилийн дотор багадаа 3 жил мэргэжлээрээ ажилласан дадлага туршлагатай, гаргууд чадвартай IT-мэргэжилтэнд, дээд эсвэл мэргэжлийн диплом үнэмлэх байхгүй хэдий ч мэдээлэл, харилцааны технологийн салбарт ажиллах эрхтэй хүнд оршин суух зөвшөөрөл олгож болно. Ажил олгогчоос өгөх нэг жилийн татвар ноогдуулаагүй цалингийн (brutto Gehalt) хэмжээ 52560 Еврогоос багагүй байх бөгөөд B1 түвшний герман хэлний мэдлэгийг батлах баримттай¹ байх журамтай байдаг. Үндэслэлтэй тайлбар бүхий зарим тохиолдолд герман хэлний мэдлэгийг батлах баримтыг шаардахгүй байж болно.

Германд ажиллаж амьдрах тухай дэлгэрэнгүй мэдээллийг: www.make-it-in-germany.com



Визийн мэдүүлэгт өгөх бичиг баримтын жагсаалт

Визийн мэдүүлэгт өгөх бичиг баримтуудыг эх хувиас гадна 2 хувь хуулбарын хамт өгнө.
Англиас бусад хэл дээрх бичиг баримтыг герман орчуулгын хамт өгнө.

Бичиг баримтаа доорх дарааллаар эрэмбэлнэ үү.

| | | |
|---|---|--------------------------|
| 1 | Бүрэн гүйцэд бөглөсөн, виз мэдүүлэгч гарын үсгээ зурсан үндэсний визийн маягт 2 хувь ("VIDEX" маягт) | <input type="checkbox"/> |
| 2 | Биометрийн шаардлага хангасан 35*45 мм хэмжээтэй 2 хувь цээж зурагны нэгийг үндэсний визийн маягтын цээж зураг байрлах хэсэгт нааж хоёр дахь зургийг нь наалгүй авч ирнэ. | |
| 3 | Хүчинтэй гадаад паспорт | |
| 4 | Гадаад паспорт эзэмшигчийн хувийн мэдээлэл бүхий нүүрнээс хийсэн хуулбар | |
| 5 | Ажил ологчийн зүгээс бөглөж эрх бүхий этгээд гарын үсэг зурсан „Erklärung zum Beschäftigungsverhältnis“ маягт эх хувиараа | |
| 6 | 45 нас хүрсэн виз мэдүүлэгч: Татвар төлөөгүй нэг жилийн цалингийн хэмжээ (brutto Gehalt) 48180 Евро хүрэхгүй байвал - Өндөр насны тэтгэврийн зөрүүг нөхөн олгох тухай баримт эх хувь хуулбарын хамт (2023 оны байдлаар). | |
| 7 | Байгаа бол: Холбооны Хөдөлмөрийн Товчооны урьдчилан олгосон зөвшөөрөл (Vorabzustimmung der Bundesagentur für Arbeit) | |
| 8 | Эрүүл мэндийн даатгалын баримт Ажил олгогчийн талаас хийсэн хууль ёсны эрүүл мэндийн даатгал нь Германд оршин суугаа хаягийн бүртгэлтэй, хөдөлмөрийн гэрээтэй байгууллагадаа ажиллаж эхэлснээс хойш хүчин төгөлдөр үйлчилнэ. Хөдөлмөрийн харилцаа эхлэхээс өмнө Германд ирэх бол хувийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байх шаардлагатай. Богино хугацааны аяллын эрүүл мэндийн даатгал нь Германд үргэлжлүүлэн удаан хугацаагаар оршин суух тохиолдолд нөхөн олговрын нөхцлүүд үйлчлэхгүй болж болох юм. „Incoming-Versicherungen“ төрлийн даатгал ч мөн адил урт хугацаагаар оршин суух тохиолдолд нөхөн төлбөрийн нөхцлүүд хүчин төгөлдөр бус болох магадлалтай. | |

Дээд боловсролтой ажиллах хүчин

| | | |
|-----|--|--|
| 9.1 | Мэргэжлийн ур чадварын баримт: Их / Дээд сургуулийн диплом, дипломын хавсралт эх хувиараа | |
| 9.2 | Гадаадын дээд боловсрол / мэргэжлийг Германд хүлээн зөвшөөрсөн баримт: Мэргэжлийн боловсрол эзэмшсэн ажиллах хүчний хувьд: – Гадаадын мэргэжлийн боловсролыг Германд хүлээн зөвшөөрсөн тухай шийдвэр: Холбооны Муж улсын холбогдох газраас олгосон бичгэн зөвшөөрөл Дээд боловсрол эзэмшсэн ажиллах хүчний хувьд: - anabin Datenbank – мэдээллийн сангаас авсан тодорхойлолт Таны Диплом, төгссөн дээд сургууль <i>anabin</i> -ны мэдээллийн санд | |

Энэхүү жагсаалтыг ЭСЯ тухайн цаг үеийн мэдлэг, дүгнэлт дээр үндэслэн гаргасан болно. Жагсаалтын бүрэн гүйцэд, үнэн зөв байдал ялангуяа цаг хугацааны хувьд гарч болох өөрчлөлтүүдийн өмнөөс ЭСЯ хариуцлага хүлээхгүй.



| | | |
|--|---|--|
| | <p>ороогүй бол:</p> <ul style="list-style-type: none"> - ZAB (Zentralstelle für ausländisches Bildungswesen) – аас авсан Гэрчилгээний үнэлгээ (Zeugnisbewertung) <p>эсвэл</p> <p>зөвшөөрөл шаардлагатай мэргэжил (Ж нь: <i>Эмч, Инженер гэх мэт. Бүрэн жагсаалтыг Bundesagentur für Arbeit–аас эсвэл EU-Kommission үзнэ үү</i>) бол:</p> <ul style="list-style-type: none"> - Мэргэжлээрээ ажиллах зөвшөөрөл эсвэл мэргэжлээрээ ажиллахыг урьдчилан зөвшөөрсөн тодорхойлолт (Zusicherung). Ж нь: анагаах ухааны дипломд олгосон Мужийн хүлээн зөвшөөрөх байгууллагын шийдвэр (Entscheidung der Approbationsbehörde im Bundesgebiet) <p>Дэлгэрэнгүй мэдээллийг: www.anerkennung-in-deutschland.de</p> | |
| Мэргэжлийн боловсролтой ажиллах хүчин | | |
| 9.3 | Мэргэжлийн диплом, үнэмлэх, хөдөлмөрийн дэвтэр хуулбар орчуулгын хамт | |
| 9.4 | <ul style="list-style-type: none"> - Гадаадын мэргэжлийн боловсролыг Германд хүлээн зөвшөөрсөн тухай шийдвэр: Холбооны Муж улсын холбогдох газраас олгосон бичгэн зөвшөөрөл эх хувиараа <p>зөвшөөрөл шаардлагатай мэргэжил (Ж нь: <i>Эмч, Инженер гэх мэт. Бүрэн жагсаалтыг Bundesagentur für Arbeit–аас эсвэл EU-Kommission үзнэ үү</i>) бол:</p> <ul style="list-style-type: none"> - Мэргэжлээрээ ажиллах зөвшөөрөл эсвэл мэргэжлээрээ ажиллахыг урьдчилан зөвшөөрсөн тодорхойлолт (Zusicherung). Жишээ нь: анагаах ухааны дипломд олгосон Мужийн хүлээн зөвшөөрөх байгууллагын шийдвэр (Entscheidung der Approbationsbehörde im Bundesgebiet) <p>Дэлгэрэнгүй мэдээллийг: www.anerkennung-in-deutschland.de</p> | |
| Мэдээллийн Технологийн (IT) ажлын туршлагатай мэргэжилтэн | | |
| 9.5 | ¹ B1 түвшний герман хэлний мэдлэгийг батлах баримт. Герман хэлний мэдлэгийн сертификат нь ALTE стандартын дагуу хэлний мэдлэгийг шалгах эрх бүхий байгууллагаас олгосон байх ёстой. Das Deutsche Sprachdiplom (DSD) – Герман хэлний дипломыг мөн хүлээн зөвшөөрнө. <i>Герман хэлний мэдлэгийг батлах баримт Зарим тохиолдолд шаардахгүй байж болно.</i> | |
| 9.6 | Сүүлийн 7 жилийн дотор багадаа 3 жил мэргэжлээрээ ажилласан дадлага туршлагатай, гаргууд чадвартай IT-мэргэжилтэн гэдгийг батлах баримт эх хувиараа | |
| 9.7 | Холбогдох онолын мэдлэгийг батлах баримт (мэргэжлийн сургалт дүүргэсэн, шалгалт өгсөн) эх хувиараа | |
| Монголоос өөр орны иргэншилтэй виз мэдүүлэгч | | |
| 10 | Монгол Улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл | |
| Хураамж | | |
| 11 | Визийн хураамж 75 Еврог монгол төгрөгөөр | |



Визийн мэдүүлгийн бүрэн гүйцэд байдал

Визийн мэдүүлэгт шаардлагатай бичиг баримт бүрэн гүйцэд байгаа эсэх:

Гийм

Гүгүй, чагтлаагүй үлдсэн бичиг баримт/мэдээлэл дутуу

Бүрэн гүйцэд бус визийн мэдүүлэг өгөх тухай мэдэгдэл

Миний визийн мэдүүлэг бүрэн гүйцэд бус байгаа талаар надад мэдээлсэн. Визийн мэдүүлэгт шаардлагатай бичиг баримт дутуу байх нь визийг татгалзах эрсдэлтэй гэдгийг миний бие ойлгож байгаа бөгөөд визийн мэдүүлгээ өгөх хэвээр байгаа гэдгийг мэдэгдэж гарын үсгээ зурсан болно.

_____ газар, огноо, гарын үсэг